



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/90

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл салбарын үйл ажиллагааны дэмжлэгт 5,000,000 төгрөгийг олгосугай.

2. Дээрх зардлын 5,000,000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын ерөнхий данснаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал) -д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулж, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг ханган, тайлагнахыг Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл салбарын дарга (Ж.Сарангэрэл)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат) -т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН